



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/80

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Булган аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрт тусгагдсан бүтээн байгуулалтын ажлуудын зураг төслийн өмнөх инженер геологийн судалгааны ажлын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.2, Засгийн газрын 2021 оны 05 сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоолын хавсралтын 2 дугаар мөрний заалт, Барилга хот байгуулалтын сайдын 2014 оны 56 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын инженер геологийн ажлын жишиг үнэ БД 81-117-13” нормыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн хүүхдийн “Жаргалант” зуслангийн барилгуудын зураг төсөл боловсруулахад шаардлагатай инженер геологийн судалгааны ажлыг “Лэнд Тест” ХХК-тай 13,129,160 (арван гурван сая нэг зуун хорин есөн мянга нэг зуун жаран) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-д олгосугай.

2.Инженер геологийн судалгааны ажлыг чанартай гүйцэтгэж, гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөхийг “Лэнд тест” ХХК (И.Сайнсанаа)-д даалгасугай.

3.Инженер геологийн судалгааны ажлын явцад байнгын хяналт тавьж, магадлалаар хянагдсан судалгааны тайланг хүлээн авахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-д даалгасугай.

4.Инженер геологийн судалгааны ажлын санхүүжилтийг гэрээнд заасан дүнгээр аймгийн 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөл, ТЭЗҮ, судалгааны ажил боловсруулах зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2023 өдөр бүр Дос/2023/Захирамж

6323010962